



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 284

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувийн хэвшлийн байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлсэн 671,225,507.00 (зургаан зуун далан нэгэн сая хоёр зуун хорин таван мянга таван зуун долоон) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид эзэмшүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



0000533

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
 2019 оны 07 дугаар сарын 28-ны өдөр
 28-дугаар тогтоолын хавс



"Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн
 дансанд бүртгэх барилга байгууламжийн жагсаалт

Объектын нэр	Объектын нэр байршил	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэм жиж нэгж	Тоо	Бүтгэлд тусгах үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл /төгрөг/
"Эрцэнг" ХХК	СБД 1 хороо Эдэльвейс зочид буудлын зүүн урд	11ж магистраль шугам	2018	хос/метр	49	293,229,334.00	0.00	293,229,334.00
		11ж-26 магистралийн холбоос шугам	2018	хос/метр	87			
"Монгол" ХХК	СБД 3 хороо Циркийн хойно	11д магистраль ДХ65-р цэгээс ДХ68-р цэг хүртэл	2018	хос/метр	98	377,996,173.00	0.00	377,996,173.00
Дүн					234	671,225,507.00 (зургаан зуун далан нэгэн сая хоёр зуун хорин таван мянга таван зуун долоон)	-	671,225,507.00 (зургаан зуун далан нэгэн сая хоёр зуун хорин таван мянга таван зуун долоон)